



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар М/69

Улаанбаатар хот

“Эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэх ажлыг
зохион байгуулах тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8, 30 дугаар зүйлийн 30.1.4, 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архидан согтууралтай тэмцэх, нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 1-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн ажилтан, алба хаагчдыг нэг сарын хугацаанд гудамж, зам талбайд эргүүлийн үүрэг гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулахыг хороодын Засаг дарга нарт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Цагдаагийн газар (хурандаа Т.Баатар)-т тус тус үүрэг болгосугай.

2. Эргүүлийн үйл ажиллагааны үр дүнг нээлттэй тайлагнаж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ